

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 06 сарын 10 өдөр

Дугаар 22/09

Улаанбаатар хот

### Хувьцаа буцаан худалдан авах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 49.1, 76.1, 76.1.7 дах заалт, Компанийн дүрмийн 8.12.8, 8.12.15 болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 сарын 09-ний өдрийн Шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. “Бодь даатгал” ХК болон иргэн Л.Отгонбаяр нарын хооронд 2021 оны 12 сарын 01-ний өдөр байгуулсан “Бодь даатгал” ХК-ийн хувьцааг буцаан худалдан авах нөхцөлтэй худалдан, худалдан авах гэрээний дагуу 2,666,667 ширхэг хувьцааг нэгж бүрийн үнэ 162.16 төгрөгөөр тооцон нийт 432,426,720 /Дөрвөн зуун гучин хоёр сая дөрвөн зуун хорин зургаан мянга долоон зуун хорь / төгрөгөөр буцаан худалдан авахыг зөвшөөрсүгэй.
2. Иргэн Д.Хулантай 2021 оны 12 сарын 01-ний өдөр байгуулсан “Бодь даатгал” ХК-ийн хувьцааг буцаан худалдан авах нөхцөлтэй худалдан, худалдан авах гэрээний дагуу 2,459,604 ширхэг хувьцааг нэгж бүрийн үнэ 166.73 төгрөгөөр тооцон нийт 410,089,774 /Дөрвөн зуун арван сая наян есөн мянга долоон зуун далан дөрөв / төгрөгөөр буцаан худалдан авахыг зөвшөөрсүгэй.
3. Хувьцааг буцаан худалдан авах, түүнтэй холбоотой гэрээг дүгнэх, холбогдох баримт бичигт гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал Б.Золбаярт олгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.БОЛДХУЯГ